



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/357

Номгон

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн  
гал тогооны тоног төхөөрөмж хүлээж авах  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын "Баянхонгор аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 2023 оны 17/57 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.45 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн гал тогооны тоног төхөөрөмжийг нийлүүлэгчээс хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

В.Наранчимэг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Э.Золзаяа Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

М.Дүгэрмаа Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан Мэргэжилтэн

М.Баярбаясгалан Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга

Ө.Заяа Эрүүл мэндийн газрын Тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Э.Долгорсүрэн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Эмнэлгийн гал тогооны тоног төхөөрөмжийг 2024 оны 06 дугаар сарын 17--ний өдрийн дотор хүлээн авч байгууллагын өмчид бүртгэж авахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Ц.Идэрмөнх)-т хариуцуулсугай.

3.Гал тогооны тоног төхөөрөмжүүдийг техникийн тодорхойлолттой тулган хүлээн авч, ажлын тайланг 06 дугаар сарын 30-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг (В.Наранчимэг)-т, Сумдын эрүүл мэндийн төвүүдэд ашиглагдах биохимийн

2.

анализаторын ашиглалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

